

**“ИЛ ТОД” БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Биелэлт
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал		
1.1	<p>Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <p>-Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;</p> <p>-Албан хаагчийн ёс зүйн дүрэм;</p> <p>-Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь;</p> <p>-Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт;</p> <p>-Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар;</p>	<p>Байгууллагын цахим хуудсанд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон хүний нөөцийн ил тод байдал цэсд төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм байршсан.</p> <p>Мөн төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг тухай бүр шинэчлэн “Үйл ажиллагааны ил тод байдал” буланд байршууллаа.</p> <p>Төрийн үйлчилгээ булангаас дараах мэдээ мэдээллийг авах боломжтой.</p> <ul style="list-style-type: none"> - Бараа импортлох ба хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах дараалал - Экспортын гэрчилгээ хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг (мал, амьтан, ургамал, түүхий эд) - Экспортын гэрчилгээ хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг (хувийн хэрэгцээний зориулалтын мах) - Экспортын гэрчилгээ хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг (нохой, муур) - Импортын мэдэгдэл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг(мал, амьтан, ургамал, түүхий эд) - Дамжуулан тээвэрлэх мэдэгдэл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг (мал, амьтан, ургамал, түүхий эд) - Шинээр эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага байгуулахад бүрдүүлэх материал - Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлын жагсаалт - Эмийн сан нээхэд анхаарах асуудлууд - Эрүүл мэндийн байгууллагын талаар иргэдэд өгөх мэдээлэл - Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан зөвлөмж - Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр бүрдүүлэх баримт бичиг - Соёл, урлагийн хяналтын чиглэлээр

		<ul style="list-style-type: none"> - Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн баримт бичиг бүрдүүлэхэд баримтлах алхмууд - Рентген кабинет, ионжуулагч туяа үүсгэгч аппарат төхөөрөмжийг ашиглах, суурилуулах болон рентген шинжилгээ хийх үед мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм - Ойн мэргэжлийн байгууллагын чиглэлээр бүрдүүлэх баримт бичиг - Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн талаар тодорхойлолт гаргуулахад бүрдүүлэх материал - Химийн хорт болон аюултай бодисын агуулахын дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх материал - Үйлдвэр аж ахуйн болон бусад байгууллагад борлуулах цахилгааны тариф - Барилгын талбайн зохион байгуулалтын зургийг хянах А/06 тоот журмын дагуу бүрдүүлэх баримт - Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан зөвлөмж - Хүнсний үйлдвэрийн технологийн хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг - Мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид бүрдүүлэх баримт бичиг - Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхлэхэд бүрдүүлэх бичиг баримт - Ургамал хорио цээр, чанарын хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг - Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт - Нийгмийн хамгааллын хяналт - Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт <p>Хууль эрх зүй буланд байгууллагын бодлогын баримт бичиг, холбогдолтой хууль, дүрэм журам, Засгийн газрын тогтоол, МХЕГ-ын даргын тушаал, албан даалгавар, НЗД-ын захирамж, албан даалгавар зэргийг шинэчлэн байршуулж байна.</p> <p>Мэдээллийн самбар хүний нөөц, төсөв санхүү, тайлан мэдээ, худалдан авах ажиллагаа, шаардлагатай бичиг баримт, хэлтсүүдийн чиг үүрэг, утасны жагсаалт, онцлох мэдээлэл гэсэн 8 хэсэгтэй. Тус самбарт давхардсан тоогоор 32 удаа баяжуулалт хийсэн. Биелэлт 100%-тай байна.</p>
1.2	Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;	<p>1.Байгууллагын веб сайт болох ub.inspection.gov.mn сайтыг wordpress 5.4.4 хувилбар болгон системийн хэмжээнд илүү боловсронгуй болгон шинэчлэл хийгдэж иргэд олон нийтэд илүү ойлгомжтой хүртээмжтэйгээр мэдээ, мэдээллийг түгээж байна.</p> <p>“Төрийн үйлчилгээ” булан ажиллуулж, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналт, Дэд бүтцийн хяналт, Хүнс, хөдөө аж ахуйн хяналт, Экспорт, импортын хяналт, Цөм</p>

		<p>болон цацрагийн хяналт, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналт, Агаарын чанарын хяналт гэсэн хяналтын 8 чиглэл бүрээр бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, дүрэм, журам, зөвлөгөө зөвлөмжийн татаж авах зориулалтаар байршууллаа. Нийт 30 баримт бичгийн жагсаалтыг энэ булангаас авах боломжтой. Мөн Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалт хийхэд ашиглах 276 хяналтын хуудсыг татаж авах хэлбэрээр тухай бүр шинэчлэн байршууллаа. .</p> <p>2. Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн арьс шир ноос ноолуурын экспортын гэрчилгээ олгох нэг цэгийн үйлчилгээгээр 385 аан-д, муур нохойн хоолны импортын гэрчилгээ 7 аан-д 14ш экспортын гэрчилгээ, хатаасан хөлдөөсөн болон шинэ жимс, жимсгэнэ, хүнсний нарийн ногоо, модо, модон материал, ДСП хавтан, кофе, кофены буурцаг, хүлэрт хөвд зэрэгт 213 ш амьтан ургамал бүтээгдэхүүний импортын мэдэгдэл, монгол гэрийн мод, модон тавилга, ургамлын хатаадас, хөрсний дээж, судалгаа шинжилгээний ургамлын дээж, жимсний дээж зэрэгт ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 57 ш-ийг тус тус олгожээ. Мөн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, дүрэм, журам, зөвлөгөө зөвлөмжийн татаж авах зориулалтаар байршууллаа.</p> <p>3. Чиглэлийн 8 хэлтсийн 16 хяналтын чиглэлээр дүрэм журам, стандартын шаардлагыг хэрхэн хангах тухай цуврал 60 онлайн видео сургалт зөвлөмж хүргэлээ.</p> <p>Биелэлт 100%-тай байна.</p>
1.3	<p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>2500-аас дээш удаа мэдээ мэдээлэл түгээх зорилт тавьсан.</p> <ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд 380 сэдвийн мэдээ мэдээллийг 1800 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, олон нийтэд хүргэж, тавьсан зорилтоо 100 хувь хангалаа. "Covid 19" вирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Асендс телевизийн студитэй хамтран 4 удаагийн цуврал шторк, 60 видео контент хийж хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр цацсан. - Веб сайтанд 2020 хяналт шалгалтын мэдээ 1125, зөвлөмж 1639, сэрэмжлүүлэг 155, сургалтын мэдээ 74, бусад 11, Тамгийн газраас үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд 291, нийт 3295 мэдээ, мэдээлэл байршсан байна.
1.4	<p>Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>2020 онд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын шуурхай албаны 70128012 утсанд хандсан иргэдийн 33500 гаруй лавлагаа асуултад хэрэгтэй мэдээллээр ханган ажиллалаа. Нийт 4302 өргөдөл, гомдлыг хүлээн авч /4258 буюу 98.09 хувьтай өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 44 1.02 хувьтай гомдол шийдвэрлэх шатандаа байна.</p>

1.5	Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх. /бичиг хэрэг/	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын системийн хэмжээнд нийт 14964 албан бичиг ирснээс хариутай-8132, хариугүй-6832, хугацаандаа байгаа-102 буюу (0,8%), хугацаандаа шийдвэрлэсэн-9205 буюу (6,8%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-79 буюу (0,008%) байна. • Мөн нийт 7559 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа байгаа- 88 буюу (8.7%), хугацаандаа шийдвэрлэсэн-7379 буюу (90.1%), хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-94 (1.2%) өргөдөл, гомдолд хяналт тавин ажиллалаа. • Албан бичиг, өргөдөл, гомдлын хугацаа хэтэрч шийдвэрлэсэн нийт 94 албан хаагчдад давхардсан тоогоор 733 анхааруулах хуудас өгсөн.
Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал		
2.1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулж хэрэгжүүлсэн байх;	<p>Байгууллагын цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэнд “Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх Журам батлах тухай Засгийн газрын 382 дугаар тогтоол мөн хүний нөөцийн холбогдол бүхий 14 дүрэм журам татаж авах хэлбэрээр байршсан байна.</p> <p>Байгууллагын хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх ажилд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлэх үүднээс Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/191 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ийг хавсралтын хамт байршуулсан.</p> <p>Засгийн газрын 2019 оны 236 дугаар тогтоолын 6 дахь заалт дагуу МХЕГ-ын даргын “Бүтэц, орон тоо, зохион байгуулалт шинэчлэн батлах” тухай 2020 оны А/05 дугаар, НМХГ-ын даргын Б/16 дугаар тушаалаар 1 сарын 17-ны өдөр 524 албан хаагчдийг шинэчлэн баталсан байна. МХЕГ-н даргын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дугаар тушаалаар 2020 оны А/05 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Агаарын чанарын хэлтэс”-ийн орон тоог өөрчилсөн.</p> <p>Улсын /ахлах/ байцаагчийн тамга, тэмдгийн судалгааг МХЕГ-т хүргүүлэн ажилласан.</p> <p>”Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр” “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд: 2020 оны жилийн эцсийн байдлаар 68 улсын /ахлах/ байцаагчийн эрх олгуулах, 1 улсын /ахлах/ байцаагчийн гээгдүүлсэн үнэмлэх шинээр олгуулах саналуудыг Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн. Жирэмсний амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй 35, шинээр томилогдсон 71, шилжүүлэн томилсон 20, ажлаас чөлөөлөгдсөн 46 албан хаагч байна. Ажлаас чөлөөлөгдсөн болон ажилд томилогдсон 117 албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийсэн. Хөдөлмөрийн чадвараа түр алдсан 185 албан хаагчийн эмнэлгийн магадлагаанд бичилт хийсэн.</p>

		<p>Засгийн газрын 2020 оны “Шинэ короновирусийн эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 30 дугаар тогтоол, 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоол, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын тушаал Б/134 дугаарын тушаалаар 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчдад 5 хоногийн цалинтай чөлөө, Б/146 дугаар тушаалаар хорогдуулсан цаг 153 албан хаагчдад тус тус олгосон.</p> <p>Мөн 92 албан хаагчдад цалинтай чөлөө олгож, 20 албан хаагчид цалингүй чөлөө олгосон. 2021 онд тэтгэвэрт гарах 13 албан хаагчийн судалгаа, 2021 оны цалингийн төсвийн судалгааг гаргаж Санхүү, аж ахуй хэлтэст хүргүүлээ.</p> <p>НМХГ-ын даргын “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” тушаалыг батлуулан нийт ажилтан, албан хаагчийн ээлжийн амралтын мэдэгдлийг өгч биеэр эдлүүлж байна.</p> <p>Хүний нөөцийн асуудлаар 480 тушаалын төслийг боловсруулан батлуулж, хариуг www.edoc.ub.gov.mn, www.smartcity.mn программд орууллаа.</p> <p>Хүний нөөцийн асуудлаар 350 өргөдөл, 312 албан бичгийг хугацаанд шийдвэрлэж хариуг www.edoc.ub.gov.mn программд оруулсан.</p> <p>НМХГ-т шинээр томилогдох, сэлгэн ажиллах албан хаагчдын, Ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдох баримт бичгийн хамт Авилгатай тэмцэх газарт 141 хүргүүлэн хянуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 1 албан хаагчид 680,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.
2.2	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх;	<ul style="list-style-type: none"> • Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 379 дүгээр тушаалаар тус газрын 30 албан тушаалын тодорхойлолт батлагдсан. 2020 оны НМХГ-ын даргын хүний нөөцийн талаарх хэрэгжүүлэх журмын дагуу 66 чиглэлийн албан тушаалын тодорхойлолтын батлуулсан. Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 143 дугаар тогтоолын дагуу байгууллагын бүтэц, орон тоо, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, мэдээллийг вэб сайтад байршуулж, тогтмол шинэчилж байна.
2.3	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх;	<p><i>Байгууллагын цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэнд “Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх Журам батлах тухай Засгийн газрын 382 дугаар тогтоол мөн хүний нөөцийн холбогдол бүхий 14 дүрэм журам татаж авах хэлбэрээр байршсан байна.</i></p> <p><i>Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө гарган биелэлтийг хангуулан ажиллаж байна. 2020 оны 01 дугаар сарын 20-ны өдөр сургалтын календарчилсан төлөвлөгөөг баталж, биелэлтийг хангуулан ажиллаж байна.</i> Сургалтын календарчилсан төлөвлөгөөнд аж ахуй нэгж байгууллагад зориулсан 306 сургалт, албан хаагчдыг чадавхижуулах 172 сургалт</p>

		зохион байгуулахаар төлөвлөсөн. Жилийн эцсийн байдлаар аж ахуй нэгж байгууллага, иргэдэд хандсан нийт 267 сургалт зохион байгуулагдаж 5564 ААНБ 19946 ажилтан, иргэд хамрагджээ. Цаг үеийн онцгой нөхцөл байдлын улмаас төлөвлөгөөнд тусгагдсан ААНБ, иргэдэд чиглэсэн бусад сургалтууд цуцлагдсан байна. Мөн албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор нийт 152 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 7049 Улсын (ахлах) байцаагчид хамрагдлаа. Байгууллагын бүтэц орон тоо хүний нөөцийн ил тод байдлын судалгааг байгууллагын вэб сайтад байршуулсан.
2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх;	Олон нийттэй харилцах хэлтэс, Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Дотоод хяналт шалгалт мониторингийн хэлтсүүд хамтран нийт 500 албан хаагчдаас цахимаар сэтгэл санамжийн судалгаа авч, байгууллагын цахим хуудаст олон нийтэд ил тод танилцуулж байна.
2.5	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 498 албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ тайланг 2020 оны 1 дүгээр сарын 15-нд Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хугацаанд нь хүргүүлэн ажилласан. НМХГ-ийн гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгийг төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2020.05.13-ны өдрийн 02-01/1951 дугаар албан бичгээр, удирдах албан тушаалтны сул орон тооны захиалгыг МХЕГ-ын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2020.04.24-ны өдрийн 02-01/1658, 2020.05.04-ны өдрийн 02-01/1815, 2020.11.27-ны өдрийн 02-01/4737 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.
2.6	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.	Дотоод хяналт шалгалт, мониторингийн хэлтэс ахлан Тамгын газрын 10 мэргэжилтэнтэй хамтран Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 510 албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ, урамшуулал олгох ажиллагаанд хяналт шинжилгээ хийлээ. Хяналт шинжилгээ хийхэд 28 албан хаагчдын үнэлгээнд өөрчлөлт орсон байна. Шалгалтын хариуг үндэслэн нийт албан хаагчдад зориулж “Зөвлөмж” хүргүүлэн ажиллалаа.
Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал		
3.1	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх;	2021 оны төсвийн төслийг боловсруулан холбогдох дээд шатны байгууллага болох Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн. Уг төсвийн төслийг 2020 оны батлагдаж ирсэн төсөвтэй харьцуулахад 2,972,172,7 сая төгрөгөөр өссөн төсвийн төсөл боловсруулж явуулсан.
3.2	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал	Байгууллагын 2019 жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл 2020 оны төсвийн төслийг байгууллагын вэб сайт болох www.ub.inspection.gov.mn ,shilendans.ub.gov.mn вэб сайт мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд

	/www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;	мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн. Биелэлт 100%-тай байна.
3.3	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх;	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр өссөн дүнгээр гаргаж Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт хүргүүлсэн, мөн сарын мэдээг байгууллагын мэдээллийн самбар болон shilendans.ub.gov.mn вэб сайтад байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг ханган ажиллаж байна.
3.4	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;	Байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын веб сайт болох www.ub.inspection.gov.mn болон shilendans.ub.gov.mn вэб сайтад мөн мэдээллийн самбарт байршуулан мэдээллээ. Биелэлт 100%-тай байна.
3.5	Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх;	2020 оны батлагдсан төсөв 8,841,931,0 сая төгрөгөөр батлагдсаж ирсэн бөгөөд 2020 оны 11 дүгээр 30-ны байдлаар 95 337,0 сая төгрөгөөр өөрчлөлт орж 8,937,268,0 сая төгрөгөөр батлагдаж ирсэн. Биелэлт: батлагдсан төсвийн дагуу төлбөр тооцоог хийж ажиллаж байна.

ХЯНАСАН:

ОНХХ-ИЙН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ /...../ Б.ЭНХЖИН

БОЛОВСРУУЛСАН:

ВЕБ ХАРИУЦСАН АЖИЛТАН /...../ Э.ЭНХ-ОЧИР